Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Хууль, эрх зүйн хэлтэс

## 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.1. | Сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр болон яамнаас бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад хууль, эрх зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэг үзүүлэх; | - | - | - | - | | Хууль эрх зүйн хэлтэс нь дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна Үүнд: • салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, • хууль тогтоомж, сайдын болон дээд шатны байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих, • салбарын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, • яамны үйл ажиллагааны хүрээнд сайд, яамны Төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэр болон яамны зүгээс бусад байгууллагатай харилцах, гэрээ байгуулахад эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлж байна. | | |
| 3.1.1 | Сайдын тушаалаар батлагдсан төсөл, арга хэмжээг ТХААГ-аас тендер сонгон шалгаруулалтад шалгарсан этгээдтэй Зөвлөх | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн явц, хувиар | 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын хавсралтад туссан 53 төсөл, арга хэмжээний гэрээг боловсруулан | - | Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байна. /100 хувь/ | Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар баталсан Монгол Улсын Төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний гэрээ байгуулна | | | гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээг байгуулсан болно. | | | барилга байгууламжийн жагсаалтын IV.1.4.1-т заасан Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад туссан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Бүсүүдэд/-ний хүрээнд: 1.Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны тушаалаар дагуу байгуулагдсан ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах нийт 2025 оны байдлаар 19 гэрээг шинээр байгуулсан. /21 гэрээ нь төсөв хэмнэлтэд тооцогдож, татагдсан тул цуцлагдсан/. 2.Мөн 2024 онд байгуулсан 19 ТЭЗҮ гэрээнүүд 112 удаагийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | батлуулсан байна. | | |
| 3.1.2 | Яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өгөх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн явц, хувиар | Байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянагдсан. | - | Байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянасан байна. /100 хувь/ | ХЭЗХ-т 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар нийт 608 албан бичиг цохогдсон бөгөөд яамны эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажуулах хариутай 404 албан бичгийг боловсруулан холбогдох газарт хүргүүлэн, бусад газар хээлтсийн албан хаагчдаас ирүүлсэн 3100 албан бичгийн хууль, эрх зүйн үндэслэлийг хянан баталгаажуулсан байна. Тодруулбал Засгийн газрын тогтоолын төсөл, Хууль, тогтоомжийн төсөл, Захиргааны хэм хэмжээний актын төсөл зэрэгт Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу саналыг тухай бүр хуулийн хугацаанд хүргүүлж байна. Мөн удирдлагаас өгсөн үүргийн дагуу яамны | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажих бусад нэгжүүдийн боловсруулсан тушаал, шийдвэр, албан бичгийн төслүүдийг тухай бүр хянаж, боловсруулсан. Тодруулбал Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/264 дугаартай тушаалаар батлагдсан "Орон сууцны дэмжлэг үзүүлэх журам"-ыг батлуулсан. Тус журмын хавсралтаар дэмжлэг авах албан хаагчдын эхний жагсаалтыг батлах чиг үүрэг бүхий ажлын хэсэг, ажлын хэсгийн удирдамж, өргөдлийн загвар болон тогтвортой ажиллах гэрээг мөн батлуулсан болно. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/264 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаартай тушаалаар батлагдсан “Сайдын зөвлөлийн ажиллах журам”, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/264 дугаартай тушаалаар батлагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн журам”,-ыг тус тус боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт: 3 файл | | |
| 3.1.3 | Монгол Улсын Засгийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яам, сайд, Төрийн нарийн бичгийн даргаас олгосон итгэмжлэлийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж, төлөөлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална. | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн явц, хувиар | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан | - | Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яамны хууль ёсны эрх ашиг хамгаалагдсан байна. /100 хувь/ | 1. "Пик девелопмент" ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газар, Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох иргэний хэрэг. /16.5 тэрбум нэхэмжлэл- Ялсан/ 2. "Огторгуйн цамхаг" ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох иргэний хэрэг. /ЭЗХЯ-д ашигтайгаар эвлэрч | 100% | 100% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэрлэсэн/ 3. Эдийн засаг, хөгжлийн яамны нэхэмжлэлтэй Хос мөнгөн зам ХХК-д холбогдох арбитрын хэрэг /Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд явж байна. Шинжээч томилогдсон/ 4. Алтай трест ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох иргэний хэрэгт яамны итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож байна. /Одоогийн байдлаар тус хэргийн шүүх хурлын тов тодорхойгүй байна/ 5. Хил хязгааргүй алхам НҮТББ-ын нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яаманд холбогдох Захиргааны хэрэг /Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхэд буцаан шийдвэрлэсэн- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа | | |

8

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үргэлжилж байна./ 6. "Худалдаа хөгжлийн банк" ХК-ын нэхэмжлэлтэй "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-д холбогдох иргэний хэрэг /ЭЗХЯ бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээдээр- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна./ 7. "Баянгол ресорт" ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох барааны тэмдэг баталгаажуулах шуурхай үйлчилгээний тариф хүчингүй болгуулах нэхэмжлэлтэй Захиргааны хэрэг. /Давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна./ 8. Эн Си Эф ХХК-ийн нэхэмжлэлтэй Эдийн засаг, хөгжлийн яаманд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох захиргааны хэрэг /Анхан шатны шүүхээс урьдчилсан хэлэлцүүлгээр ЭЗХЯ-аас гаргасан хүсэлт, тайлбарын дагуу хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн/ 9. “Кью Эс Си” ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газарт холбогдох Засгийн газрын 2022 оны 148 дугаар тогтоолтой холбоотой захиргааны хэрэг /Анхан шатны журмаар ялаад байгаа. Давж заалдах эсэхийг хүлээж байна/ 10.”Улаан Дөл” ХХК-ийн нэхэмжлэлтэй Үндэсний аудитын газарт холбогдох хэрэг. /Хяналтын шатны шүүхээс хүлээн авч хэлэлцэх эсэхийг хүлээж байгаа/<br>Хавсралт: 7 файл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.4 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, зохион байгуулна. | Үйл ажиллагааны зардлаар | Хуулийн хугацаанд мэдүүлсэн байх, хувиар | 2024 онд албан хаагчид 100 хувь мэдүүлсэн. | - | Хуулийн хугацаанд нийт албан хаагчид мэдүүлсэн байна. /100 хувь/ | Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1. Эдийн засаг, хөгжлийн яам болон түүний харьяа байгууллагын нийт 308 хүний хөрөнгө орлогын мэдүүлгийг 2025.02.15-нд Шинэчлэн гаргуулсан. Мөн 2025 оны байдлаар 141 албан хаагчдын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хуульд заасан хугацаанд хянуулсан болно. 2. Meduuleg.iaac.mn цахим систем, Эдийн засаг, хөгжлийн яамны веб сайт болон | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Shilendans.gov.mn цахим системүүдэд Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл, тайлбарыг тухай бүр бүртгэж байгаа болно. 3. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Нийтийн албан тушаалтны хориглолт хязгаарлалтыг танин мэдүүлэх зорилгоор Эрх бүхий албан тушаалтан болон Авлигатай тэмцэх газраас 3 удаагийн танхим, цахим хосолсон сургалтыг яамны албан хаагчдын дунд хийсэн болно. 4. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/258 дугаар тушаалаар Эдийн засаг, хөгжлийн яамны харьяа "Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн","Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн", "Ургамал, газар тариалангийн хүрээлэн", "Ургамал | | |

12

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн", "Уламжлалт, анагаах ухаан, технологийн хүрээлэн", "Анагаах ухааны хүрээлэн"-ийн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд чанарын шаардлага хангаж байгаа эсэх төслийн үр дүн бодитой хэрэгжиж, хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх дээр хяналт тавих, авлига албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой хууль тогтоомжийг танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан харьяа байгууллагын нийт 500 гаруй албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалтыг орсон. | | |
| 3.1.5 | Долоо хоног бүрийн Засгийн газрын хуралдаанаар | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн явц, хувиар | 2024 оны Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх | - | 2025 оны Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх | Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтын /нийт | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлэлцэх асуудалд тус яамны хүргүүлсэн саналуудын жагсаалтыг нэгтгэн боловсруулна | | | асуудлын жагсаалтыг тухай бүр гаргасан. | | асуудлын жагсаалтыг тухай бүр гаргасан байна. /100 хувь/ | 30/ ЭЗХЯ-ны саналын товьёогийг 2025 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн Төрийн нарийн бичгийн дарга болон Сайдад тухай бүр хүргүүлсэн болно. Мөн түүнчлэн Эдийн засаг, хөгжлийн яамнаас Засгийн газрын ирэх 100 хоногийн албан даалгаварт тусгах саналыг, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны I-IV улирлын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг, Улсын Их Хурлын 2025 оны хаврын болон намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийх мэдээллийн сэдвийг (ЭЗХЯ-наас) болон Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын болон намрын ээлжит чуулганаар өргөн мэдүүлж хэлэлцүүлэх хууль тогтоомжийн төслийн мэдээллийг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагын нэгж бүрээс саналыг нь авч нэгтгэн боловсруулж, хүргүүлсэн бөгөөд Төрийн нарийн бичгийн дарга нарын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд туссан арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг бэлтгэн хүргүүлсэн болно. | | |
| 3.1.6 | Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг хянах, эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, архив үүсгэнэ | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн явц, хувиар | Гэрээний төслийг хянах, эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн байна. | - | Яамны хэмжээнд байгуулагдаж буй гэрээний төслийг хянах, эрх зүйн үндэслэлийг хангуулах, шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл, дэмжлэгээр хангах, гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн байна. /100 | 2025 оны жилийн эцсийн байдлаар Эдийн засаг, хөгжлийн яамны хэмжээнд байгуулагдаж буй бүх гэрээний төслийг боловсруулж, хянаж, нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох, архив үүсгэх ажиллагааны хүрээнд дараах үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн болно: 1. 2025 оны Гэрээний нэгдсэн бүртгэл хөтлөх, дугаар олгох ажиллагааг тухай бүр хийж гүйцэтгэсэн бөгөөд 2025 оны байдлаар 79 гэрээнд дугаар | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувь/ | олгон баталгаажуулсан байна. Тухайлбал: - Байгууллагын ХХАГ, Үйлчилгээ үзүүлэх гэрээ, Ажил гүйцэтгэх гэрээ, Хөдөлмөрийн гэрээний нэгдсэн загварыг боловсруулсан, - Заалны түрээсийн гэрээний төслүүд, Үйлчилгээ үзүүлэх гэрээний төслүүд, Ажил гүйцэтгэх гэрээний төслүүд, Хөлсөөр ажиллах гэрээний төслүүд, ХХАГ-ний төслүүдийг боловсруулж, хянасан, -Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 21 аймгийн засаг дарга болон Нийслэлийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээ, - Төрийн албаны реформ-Бидний шийдэл" Төрийн албан хаагчийн эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэвлэн гаргах ажил гүйцэтгэх гэрээ, -Хуулийн төсөл боловсруулагчийн арга зүйн сургалт зохион байгуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ, -Аврагч спорт хорооны заалаар үйлчлүүлэх үйлчилгээ үзүүлэх гэрээ, -Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ төсөл арга хэмжээний Багц тендерийн гэрээнүүд, -Австралийн холбооны улсын канберрагийн их сургуулийн оюутан болон албан байгууллага хоорондын гэрээ, -Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний ажил гүйцэтгэх гэрээ, -ЭЗХЯ-ны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газрын даргын зөвлөхтэй байгуулах зөвлөх үйлчилгээний гэрээ, -Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим ашиглах үйлчилгээ үзүүлэх гэрээ, -Туушин зочид буудлын танхим ашиглах үйлчилгээ үзүүлэх гэрээ г.м гэрээний төслийг боловсруулж,хууль зүйн үндэслэлийг хянасан. 2.Мөн яамны хэмжээнд байгуулагдсан 2023, 2024 онд гэрээнүүдийг архивын нэгж үүсгэн Архивын эрхлэгчид хүлээлгэн өгсөн. | | |
| 3.1.7 | Салбарын хуулийн төсөл боловсруулах, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангана. | Улсын төсвөөр | Гүйцэтгэлийн явц, хувиар | - | - | Салбарын хууль давхардал, хийдэл, зөрчлийг судалж арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоо сайжирсан байна. /100 хувь/ | 2025 оны жилийн эцсийн байдлаар дараах хууль, тогтоомжийг боловсруулах ажлын хэсэгт оролцсон: 1.Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл; 2.Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах тухай хуулийн төсөл; | 100% | 80% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3.Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн төсөл;<br>4.Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай МУЗГ болон Бүгд Найрамдах Сингапур Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрийн төсөл;<br>5.Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай МУЗГ болон Швейцарын Холбооны Зөвлөл хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрийн төсөл;<br>6.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл;<br>7.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлаар Засгийн газраас баталсан төлөвлөгөөний дагуу “Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааг сэргээх, дахин байгуулах боломжийг судалж, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | санал боловсруулах” ажлын хүрээнд Үндэсний хөгжлийн хүрээлэнтэй хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох асуудлаар судалгаа хийж, хууль зүйн санал, дүгнэлт боловсруулсан;<br>8.Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах, Засгийн газраас батлагдан, хэрэгжиж байгаа хэм хэм тогтоосон актуудад, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 191 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн баталсан “Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж”-ийн хүрээнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж,10 журмыг бүхэлд нь хүчингүй болгож, холбогдох зохицуулалтыг хуульд тусгах ажлыг зохион байгуулах | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | саналыг хүргүүлсэн; 9.Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл; 10.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл; 11.Яамны "Хөдөлмөрийн дотоод журам", "Орон сууцны дэмжлэг үзүүлэх журам" шинэчлэн батлуулсан; 12.Зөвшөөрлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл. Мөн түүнчлэн яамнаас боловсруулсан бусад хуулийн төслүүдэд тухай бүр хууль, эрх зүйн дүгнэлт хийж, санал хүргүүлэн ажиллаж байна. Хавсралт: 3 файл | | |
| 3.1.8 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн явц, хувиар | Тус яамны 2024 оны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө" бүрэн хэрэгжсэн | - | Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг гаргах, албан хаагчдыг сургалтад | Эдийн засаг, хөгжлийн яамны "2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулан 2025 оны 02 дугаар сарын | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулна | | | | | хамруулна. /100 хувь/ | 10-ны өдөр батлуулсан. Мөн яамны албан хаагчдад төлөвлөгөөг танилцуулах зорилгоор teams-д болон 1 давхрын "Шударга ёс хөгжил дэвшил 110" самбарт цаасан хэлбэрээр байршуулсан. Тус төлөвлөгөөнд туссан дараах ажлуудыг 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар хэрэгжүүлээд байна. 1. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарыг ажилуулж АТГ-аас холбогдох материалуудыг тухай бүр авч самбарыг шинэчилэн ажилласан. 2. Нийт албан хаагчдын дунд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | – | зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, Хөрөнгө орлогын мэдүүлэг зэргийг хэрхэн мэдүүлэх талаах сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр орсон. 3. Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Эдийн засаг, хөгжлийн яам түүний харьяа газруудын албан хаагчдад "АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТҮҮНИЙ ХОР ХӨНӨӨЛ" сэдвээр танхимын сургалтыг хийсэн. 4. Мөн төлөвлөгөөнд туссан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 14 мега | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төслийн талаар авлигатай тэмцэх газрын комиссаруудтай уулзан санал зөвлөмж солилцсон болно. 5. Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтыг харьяа байгууллагуудын албан хаагчдыг мөн хамруулах байдлаар 2 дугаар сард цахимаар зохион байгуулсан. 6. Ил тод байдлыг сайжруулах зорилгоор яамны вэб сайтын ил тод мэдээллийн хэсгийг шинэчлэн, Авлигатай тэмцэх газарт ил тод болгосон мэдээллийн жагсаалтыг гарган өгч хамтран ажилласан. 7.ЭЗХЯ-ны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.3-т зааснаар авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, уриалах зорилго | | |

24

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүхий видео бичлэгийг 2025.12.03-ны өдөр цахим хуудаст байршуулсан.<br>Хавсралт: 6 файл | | |
| 3.1.9 | Нууцын асуудлыг эрхлэн хөтөлнө. | Үйл ажиллагааны зардлаар | Гүйцэтгэлийн явц, хувиар | Нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдсан | - | Тухай бүр хөтөлсөн байна. /100 хувь/ | Төрийн болон албаны нууцыг хөтлөх, хамгаалах, боловсруулахтай холбогдох ажиллагааг шуурхай, тасралтгүй цаг тухайд нь хэрэгжүүлсэн болно. Тайлант хугацаанд дээрх хууль тогтоомжийг зөрчсөн аливаа нэгэн зөрчил гаргаагүй болно. Яамны бүтэц, стратеги, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан хаагчдын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, ЭБАТ-ны жагсаалтыг шинэчлэн Тагнуулын ерөнхий газарт хүргүүлж батлуулсан болно. Мөн түүнчлэн | 100% | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тагнуулын ерөнхий газар болон ЗГХЭГ-тай төрийн нууцад хамаарах гэрээний асуудлаар ТЭЗҮ-ний гэрээний холбогдох бүхий л үйл ажиллагааг үе шаттайгаар нь хариуцан гүйцэтгэсэн болно. Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууц задарч, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, нууц хадгалах, хамгаалах арга хэмжээг авахаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн болно:<br>-Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан бүрэн эрх, 27, 28 дугаар зүйлд заасан үүргийн хүрээнд эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хуулиар хүлээсэн хариуцлагыг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өндөржүүлэн ажилласан; -Жил бүрийн 01 дүгээр сард багтаан Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг боловсруулж ирүүлэх үүргийг 2025 оны 01 дүгээр сард багтаан хүргүүлсэн; -Эрхэлсэн салбар, харьяа байгууллагуудад ТЕГ-аас ирүүлсэн зөвлөмж, зааварчилгаа, үүрэг даалгаврыг уламжлан хүргүүлсэн; -Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг шинэчлэн боловсруулсан; -Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл тэмдэглэгээ тавьж бэхжүүлэхэд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй нууцын хууль тогтоомжид заасан загвар, маягт, дардсыг | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэглэж ажиллаж байна. | | |

*Үнэлсэн:* *И.Батхүү*

*Төрийн нарийн бичгийн дарга* *И.Батхүү* /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*

*Тайлагнасан:* *Д.Ариунбилэг*

*Хууль, эрх зүйн хэлтсийн дарга* *Д.Ариунбилэг* /................................/

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*